*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

СТРАТЕГИ, БОДЛОГО,ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН ШУУДАН, ӨРГӨН НЭВТРҮҮЛЭГ, ЦАХИМ ХУДАЛДААНЫ БОДЛОГО ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Б.ТУНГАЛАГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| ЗОРИЛТ 1. "САЛБАРЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 1 | **Дэд арга хэмжээ: 1.1.1.** Шуудангийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, оруулах хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэг байгуулж, ажлын хэсгийн хуралдаан болон холбогдох зохион байгуулалтыг хангаж ажиллана. | Байгуулсан ажлын хэсгийн тоо болон хуралдааны тоо | - | 1 | Шуудангийн тухай хуульд нэмэлт ,өөрчлөлт оруулахтай холбоотой санал боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг ЦХХИХХ-ны Сайдын 2025 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн А/73 дугаартай тушаалаар байгуулсан. Тус ажлын хэсгийн хуралдааныг 2 удаа зохион байгуулсан. Ажлын хэсгийн ахлагч холбогдох ажлуудыг ажлын хэсгийн гишүүдэд хуваарилан холбогдох судалгаануудыг хийж ажлын хэсгийн гишүүдэд танилцуулсан. Тус ажлын хүрээнд 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдөр болон 05 дугаар сарын 16-ны өдрүүдэд Улсын Их Хурлын Инновац цахим бодлогын байнгын хороонд Шуудангийн тухай хуулийн хэрэгжилт болон тус хуульд нэмэлт өөрчлөлт оруулах талаар мэдээлэл хийсэн. Мөн шуудангийн үйлчилгээ үзүүлэгч оролцогч талуудаас хуулийн нэмэлт өөрчлөлт оруулах санал болон Шуудан, цахим худалдааны бодлого, зохицуулалтын үйл ажиллагаанд тусгах санал авахаар шуудангийн үйлчилгээ үзүүлэгч 24 байгууллагад 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн | 04.01-06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 01/1278 дугаартай албан бичиг хүргүүлэн саналыг хүлээн авч ажиллаж байна. | | |
| | **Дэд арга хэмжээ: 1.1.2.** Шуудангийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, оруулах хуулийн төслийн үзэл баримтлал боловсруулж батлуулна. | Боловсруулж, батлуулсан үзэл баримтлалын тоо | - | 1 | Тайлант хугацаа болоогүй. | 08.01-10.01 | - |
| | **Дэд арга хэмжээ: 1.1.3.** Шуудангийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, оруулах хуулийн төслийн хэлэлцүүлэг хийж, олон нийтээс санал авна. | Хэлэлцүүлгийн тоо | - | 1 | Тайлант хугацаа болоогүй. | 10.01-11.30 | - |
| | **Дэд арга хэмжээ: 1.1.4.** Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцооны судалгаа хийнэ. | Судалгааны тоо | - | 1 | Тайлант хугацаа болоогүй. | 10.01-11.30 | - |
| | **Дэд арга хэмжээ: 1.1.5.** Шуудангийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, оруулах хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын гишүүдээс санал авч нэгтгэн Засгийн газарт хүргүүлнэ. | Хүргүүлсэн хуулийн төслийн тоо | - | 1 | Тайлант хугацаа болоогүй. | 10.01-12.15 | - |
| 2 | **Дэд арга хэмжээ: 1.2.1.** Дэлхийн шуудан холбооны дүрмийн 11 дүгээр нэмэлт өөрчлөлт оруулах үзэл баримтлалын судалгаа хийнэ | Судалгааны тоо | - | 1 | Дэлхийн шуудан холбооны дүрмийн 11 дүгээр нэмэлт протоколын үзэл баримтлалын төсөл батлуулахад шаардагдах судалгааг боловсруулсан. | 01.02-05.01 | 100 |
| | **Дэд арга хэмжээ: 1.2.2.** Дэлхийн шуудан холбооны дүрмийн 11 дүгээр нэмэлт протоколын үзэл баримтлал боловсруулж, батлуулна. | Боловсруулж, батлуулсан үзэл баримтлалын тоо | - | 1 | Дэлхийн шуудан холбооны дүрмийн 11 дүгээр нэмэлт протоколын үзэл баримтлалын төслийг боловсруулсан. | 05.01-08.01 | 70 |
| | **Дэд арга хэмжээ: 1.2.3.** Дэлхийн шуудан холбооны дүрмийн 11 дүгээр нэмэлт протоколын төслийг боловсруулан, Засгийн | Хүргүүлсэн хуулийн төслийн тоо | - | 1 | Тайлант хугацаа болоогүй. | 08.01-09.30 | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | газрын гишүүдээс санал авч нэгтгэн Засгийн газарт хүргүүлнэ. | | | | | | |
| 3 | **Дэд арга хэмжээ: 1.3.1.** Хаягжуулалтын тухай хуулийн төсөлд салбарын санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн хуралдаан болон холбогдох зохион байгуулалтыг хангаж ажиллана. | Байгуулсан ажлын хэсгийн тоо болон хуралдааны тоо | - | 1 | Сайдын 2024 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн А/73 тушаалаар байгуулагдсан Хаягжуулалтын тухай хуулийн төсөлд санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн анхдугаар хуралдааныг 2024.12.19-ны өдөр зохион байгуулсан. | 01.02-06.01 | 100 |
| | **Дэд арга хэмжээ: 1.3.2.** Хаягжуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсэгт ажиллаж, салбараас тусгуулах саналуудыг нэгтгэн боловсруулж хүргүүлнэ. | Хүргүүлсэн саналын тоо | - | 1 | Хуулийн төсөлд хүргүүлэх саналыг боловсруулж 2025 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 01/164 дугаартай албан бичгээр Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газарт хүргүүлсэн. Мөн тус хуулийн төслийн боловсруулах ажлын хэсгийг 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн А/144 дугаартай Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын тушаалаар шинэчлэн баталсан. Ажлын хэсэгт тус яамнаас Сайдын зөвлөх М.Тулгат, Салбарын эрх зүйн орчны шинэчлэл, хуулийн хэлтсийн дарга Л.Нямдорж болон Б.Тунгалаг миний бие оролцон ажиллаж, хуулийн үзэл баримтлалын төсөл болон хуулийн төсөлд санал тусган ажилласан. | 01.02-06.30 | 100 |
| 4 | **Дэд арга хэмжээ: 1.4.1.** Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс хооронд байгуулах Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн Үйлчилгээний худалдааны бүлгийн Ажлын хэсэгт тухай бүр ажиллана. | Ажлын хэсэгт ажилласан эсэх | - | 1 | Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс хооронд байгуулах Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн Үйлчилгээний худалдааны бүлгийн Ажлын хэсэгт ажиллаж, 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр ЭЗХЯ, ЦХИХХЯ, ХХЗХ-ны төлөөлөл хуралдаж Монгол, Солонгос хоёр улсын эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн Үйлчилгээний худалдааны бүлэгт хамаарах харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарт 2 улсын харилцан хориглох заалтуудыг тус бүрчлэн хэлэлцэж санал солилцсон. | 01.02-06.30 | 100 |
| | **Дэд арга хэмжээ: 1.4.2.** Хэлэлцээрт Шуудан, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний салбарын хэлэлцээрт тусгах саналыг боловсруулан хүргүүлнэ. | Хүргүүлсэн саналын тоо | - | 1 | Хэлэлцээрт тусгах холбогдох санал боловсруулан 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдөр ажлын хэсгийн нарийн бичгийн дарга буюу ЭЗХЯ-ны мэргэжилтэн Э.Үүрцайхад (uurtsaikh.e@med.gov.mn) цахим шуудангаар хүргүүлсэн. Мөн Шуудан, Өргөн нэвтрүүлгийн салбарт | 01.02-03.30 | 100 |

2024 оны алдаа

2024 оны алдаа

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тусгах саналыг боловсруулан баталгаажуулж 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдөр баталгаажуулан хүргүүлсэн. | | |
| ЗОРИЛТ 2. "САЛБАРЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ, БОДЛОГЫН УДИРДАМЖААР ХАНГАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 5. | **Дэд арга хэмжээ: 2.1.1.** Шуудангийн бодлогын хэрэгжилтэд дүгнэлт, санал боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулж, ажлын хэсгийн хуралдаан болон холбогдох зохион байгуулалтыг хангаж ажиллана. | Боловсруулсан баримт бичгийн тоо | - | 1 | Шуудангийн бодлогын хэрэгжилтэд дүгнэлт, санал боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг 2025 оны 04 дүгээр сарын 21-ны өдрийн А/61 дугаартай Сайдын тушаалаар байгуулсан. Тус ажлын хэсгийн хуралдааныг 2 удаа зохион байгуулсан. Ажлын хэсгийн ахлагч холбогдох ажлуудыг ажлын хэсгийн гишүүдэд хуваарилан холбогдох судалгаануудыг хийсэн. | 01.02-06.10 | 100 |
| | **Дэд арга хэмжээ: 2.1.2.** Шуудан, цахим худалдааны тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон салбарын байгууллагуудаас санал авч нэгтгэн боловсруулна. | Саналын тоо | - | 1 | 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр Мобиком корпорацийн төлөөлөлтэй Цахим худалдааны дэд бүтцийн талаар уулзалт хийж, санал солилцсон. Монгол шуудан ХК-ны зүгээс цахим худалдааны хүрээнд хийгдэж байгаа ажлуудтай танилцаж санал солилцсон.<br>Мөн шуудангийн үйлчилгээ үзүүлэгч оролцогч талуудаас хуульд нэмэлт өөрчлөлтөд оруулах санал болон Шуудан, цахим худалдааны бодлого, зохицуулалтын үйл ажиллагаанд тусгах санал авахаар шуудангийн үйлчилгээ үзүүлэгч 24 байгууллагад 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 01/1278 дугаартай албан бичиг хүргүүлсэн. | 05.20-06.30 | 100 |
| | **Дэд арга хэмжээ: 2.1.3.** Шуудангийн өнөөгийн нөхцөл байдал болон олон улсын шуудан цахим худалдааны хөгжлийн талаар судалгаа хийнэ. | Судалгааны тоо | - | 1 | Тайлант хугацаа болоогүй. | 06.30-08.30 | - |
| | **Дэд арга хэмжээ: 2.1.4.** Шуудан, цахим худалдааны бодлогын баримтлах чиглэлийн төсөл боловсруулна. | Боловсруулсан баримт бичгийн тоо | - | 1 | Тайлант хугацаа болоогүй. | 06.30-12-15 | - |
| | **Дэд арга хэмжээ: 2.2.1.** "Ази, Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх ерөнхий хэлэлцээр"-ийн | Боловсруулсан баримт бичгийн тоо | | 1 | Гадаад хэргийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/02 тушаалаар батлагдсан "Ази, Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх тухай ерөнхий хэлэлцээр"-н хэрэгжилтийг хангах үүрэг бүхий | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6. | "Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө"-нд тусгах арга хэмжээний төсөл боловсруулна. | | - | | ажлын хэсэгт ажиллаж "Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө"-нд салбарын онцлог болон цаашид хийгдэх ажлуудад санал тусгаж ажилласан. Мөн НҮБ-ын Ази, Номхон далайн бүс нутгийн эдийн засаг, нийгмийн комисс болон Европын худалдааны байгууллага, Гадаад харилцааны яам хамтран 2025 оны 03 дугаар сарын 24-28-ны өдрүүдэд зохион байгуулсан "Монголын цахим худалдааны долоо хоног" арга хэмжээнд оролцсон. | 01.02-03.30 | 100 |
| | **Дэд арга хэмжээ: 2.2.2.** "Ази, Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх ерөнхий хэлэлцээр"-ийн хэрэгжилтийг хангах үүрэг бүхий Ажлын хэсэгт ажиллаж, салбарт хамаарах ажлуудын хэрэгжилтийг хангаж ажиллана. | | | | Тус ажлын хэсгийн хүрээнд 2025 оны 04 дүгээр сарын 15-19-ны өдрүүдэд ажлын хэсгийн гишүүд Дорноговь Замын Үүд, БНХАУ-ын Эрээн хотын хилийн боомтуудад ажиллаж хил дамнасан худалдааг хөнгөвчлөх, цаасгүй мэдээлэл солилцооны бэрхшээлийг газар дээр нь судлах, олон улсын сайн туршлагаас судлах, Мөн цаашид хил гаалийн үйл ажиллагаанд цахим бүрдүүлэлтийг нэвтрүүлэх, мэдээллийн зөрчлийг арилгах, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх замаар экспорт, импортын үйл явцыг хялбаршуулах талаар холбогдогч талуудтай санал солилцож ажилласан. **Тайлант хугацаа болоогүй.** | 01.02-12.15 | - |
| 7. | **Арга хэмжээ 2.3.** Замын Үүд боомтод шуудан, логистикийн төв байгуулах техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын даалгавар боловсруулж, батлуулна. | Боловсруулж, батлуулсан баримт бичгийн тоо | - | 1 | Замын-үүд боомтын шуудан, логистикийн төв байгуулах төслийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын даалгаврыг боловсруулан Төрийн нарийн бичгийн даргаар батлуулж Эдийн засаг хөгжлийн яаманд хүргүүлсэн. Тус ажлын даалгаврын дагуу Төрийн худалдан авах ажиллагааны tender.gov.mn цахим хуудсаар Замын Үүд боомтод шуудан, логистикийн төв байгуулах ТЭЗҮ боловсруулах худалдан авах ажиллагаа зарлагдсан. | 01.02-06.10 | 100 |
| 8. | **Арга хэмжээ 2.4.** Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2025 оны төлөвлөгөө боловсруулж, батлуулна. | Боловсруулж, батлуулсан баримт бичгийн тоо | - | 1 | Яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулахтай холбогдуулан ЗГҮАХ 2024-2028, Яамны стратеги төлөвлөгөө 2024-2028, Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Монгол улсын хөгжлийн төлөвлөгөө 2025, Яамны 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, Газар, хэлтсүүдийн 2025 оны төлөвлөгөөний төслүүд зэрэг баримт бичгүүдээс төлөвлөгөөний төсөлд тусгах холбогдох төсөл, арга хэмжээнүүдийг нэгтгэн боловсруулж газрын дарга нарын хурлаар хэлэлцүүлж, 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр батлуулсан. | 01.02-06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 9. | **Арга хэмжээ 2.5.** Стратеги, бодлого, төлөвлөлтийн газрын 2025 оны төлөвлөгөө боловсруулж, батлуулна. | Боловсруулж, батлуулсан баримт бичгийн тоо | - | 1 | Нэгжийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулахтай холбогдуулан ЗГҮАХ 2024-2028, Яамны стратеги төлөвлөгөө 2024-2028, Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Монгол улсын хөгжлийн төлөвлөгөө 2025, Яамны 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, Яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө зэрэг баримт бичгүүдээс төлөвлөгөөний төсөлд тусгах холбогдох төсөл, арга хэмжээнүүдийг нэгтгэн боловсруулж 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. | 01.02-06.10 | 100 |
| ЗОРИЛТ 3. "ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 10. | **Арга хэмжээ 3.1.** ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг холбогдох журамд заасан хугацаанд боловсруулж батлуулах, тайлагнах | Батлуулсан төлөвлөгөөний тоо, тайлангийн тоо | 0 | 2 | • Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг хуулийн хугацаанд боловсруулж, нэгжийн удирдлагаар баталгаажуулсан.<br>• Төлөвлөгөөний хагас жилийн биелэлтийг батлагдсан загварын дагуу 2025 оны 06 дугаар сарын 10 өдөр тайлагнасан. | 01.02-06.10 | 100 |
| 11. | **Арга хэмжээ 3.2.** Чиг үүргийн дагуу төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх | Хүргүүлсэн биелэлтийн тоо | 0 | 1 | Газрын хэмжээнд бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг өөрийн чиг үүргийн хүрээнд тухай бүр боловсруулан тайлагнасан. | 01.02-06.10 | 100 |
| 12. | **Арга хэмжээ 3.3.** Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, холбогдох журамд заасны дагуу цахогдсон албан бичиг, өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэх | Шийдвэрлэсэн албан бичгийн тоо | 0 | 1 | Нийт 46 албан бичиг хүлээн авч шийдвэрлэж холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна. | 01.02-06.10 | 100 |
| 13. | **Арга хэмжээ 3.4.** Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй | ХАСХОМ маягтын тоо, Ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдлийн тоо | 0 | 2 | 1. Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг зааврын дагуу гарган 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдөр баталгаажуулсан.<br>2. Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн Б/20 дугаар тушаалаар чиг үүрэг өөрчлөгдсөнтэй | 01.02-06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх | | | | холбогдуулан хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг зааврын дагуу гарган 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдөр баталгаажуулсан. | | |
| 14. | **Арга хэмжээ 3.5.** Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон холбогдох журамд заасны дагуу хөтлөх нэрийн жагсаалтад заасан баримт бичгийг архивлах | Архивласан баримтын тоо | 0 | 1 | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон холбогдох журамд заасны дагуу хөтлөх нэрийн жагсаалтад туссан баримт бичиг байхгүй байна. | 01.02-06.10 | 100 |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | **Үүрэг даалгавар 1.** Олон улсын зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжүүлэх төслийн санал боловсруулах | Боловсруулсан төслийн тоо | 0 | 1 | Япон Улсын Засгийн газраас Монгол Улсад олгох буцалтгүй тусламжийн хүрээнд хэрэгждэг "Эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжих хөтөлбөр"-өөр 2027 оны санхүүгийн жилд Монгол Улсад хэрэгжүүлэх төслийн саналд салбарын эрхлэх асуудлын хүрээнд хөрөнгө оруулалт шаардагдаж буй 6 төслийн санал, холбогдох материалыг боловсруулан 2025 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 03/157 дугаартай албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. Хүргүүлсэн төслийн саналд:<br>• Радио өргөн нэвтрүүлгийн дамжуулах сүлжээг DRM тоон технологид шилжүүлэх төсөл.<br>• Олон улсын болон улсын чанартай А зэрэглэлийн авто зам дагуу тоон радио өргөн нэвтрүүлгийн тасралтгүй сүлжээ байгуулах төсөл<br>• Бодит системд нэвтрүүлэлт тест хийх сургалтын төсөл<br>• Халдлагад хариу үзүүлэх чадавхыг бэхжүүлэх | 01.02-06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | • Монгол улсын дижитал ирээдүйг чадавхжуулах нь: Ур чадварын зөрүүг арилгаж, инновацыг хурдасгах төсөл<br>• Шуудангийн логистикийн дэд төв байгуулах төсөл | | |
| 2. | **Үүрэг даалгавар 2.** Гадаад хамтын ажиллагааны хүрээнд | Саналын тоо | 0 | 1 | Олон Улсын Цахилгаан холбооны байгууллагаас 2025 оны 03 сарын 17-21 өдрүүдэд Тайландын хаант улсын Банкок хотноо зохион байгуулсан "Ази, Номхон далайн бүс нутгийн хөгжлийн форум, Ази, Номхон далайн бүсийн орнуудын WTDC-25-ын 3-р бэлтгэл хурал"-д тус оролцож, хурлын дэд даргын үүргийг гүйцэтгэн ажилласан. | 01.02-06.10 | 100 |
| 3. | **Үүрэг даалгавар 3.** Бүсчилсэн хөгжлийн хүрээнд "Бүсүүдийн 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах" үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллах | Боловсруулсан төслийн тоо | 0 | 1 | Бүсчилсэн хөгжлийн хүрээнд "Бүсүүдийн 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах" үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллаж төлөвлөгөөний төсөлд тусгах салбарын саналыг нэгтгэн ажиллаж байна. | 01.02-06.10 | 100 |
| 4. | **Үүрэг даалгавар 4.** "Бүчилсэн хөгжил" хөдөлгөөн өрнүүлэх хүрээнд ажлын хэсэг байгуулах | Тушаалын тоо | 0 | 1 | Монгол Улсын Шадар сайд С.Амарсайханы 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдөр баталсан "Бүчилсэн хөгжил" хөдөлгөөн өрнүүлэх тухай удирдамж, Бүсчилсэн хөгжлийн үндэсний хорооны 2025 оны 01 дүгээр тогтоолоор баталсан "2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө"-нд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд 7 бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдааны үеэр "Бүсийн цахим шилжилт, өндөр технологи нэвтрүүлэлт" сэдэвт салбар хуралдааныг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг, Бүсийн хамтын ажиллагааг дэмжих, идэвхжүүлэх хөдөлгөөн өрнүүлэх хүрээнд "Олон талт арга хэмжээ" зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн тушаалын төслийг боловсруулсан батлуулсан. | 01.02-06.10 | 100 |
| 5. | **Үүрэг даалгавар 5.** Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд санал боловсруулан хүргүүлэх | Саналын тоо | 0 | 1 | Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд санал боловсруулан 2025 оны 03 дугаар сарын 19-ны өдрийн 01/618 дугаартай албан бичгээр Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний хороонд хүргүүлсэн. | 01.02-06.10 | 100 |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | **Арга хэмжээ 1.** Хариуцсан ажлын чиглэлээр байгууллагаас болон бусад газраас зохион байгуулсан хурал, зөвлөгөөнд оролцох | Тухай бүр холбогдох хурал, зөвлөгөөнд хамрагдсан байна. | 0 | 1 | 1. Ази номхон далайн шуудан холбооны газраас 2025.01.13-01.24 өдрүүдэд зохион байгуулж буй "Postal Strategy: Formulation and Execution" онлайн сургалтад хамрагдаж сертефикат авсан.<br>2. ESCAP-аас 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсан "Бүс нутгийн дижитал худалдааны тогтолцоонд оролцоог нэмэгдүүлэх" зөвлөлдөх уулзалтад оролцсон.<br>3. 2025 оны 03 дугаар сарын 24-28-ны өдрүүдэд зохион байгуулсан "Монголын цахим худалдааны долоо хоног" арга хэмжээнд оролцсон.<br>4. 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдөр Хиймэл оюунд суурилсан дэвшилтэт технологийг нэвтрүүлж, Монголын гаалийн шинэчлэлийг бэхжүүлэх төслийн уулзалтад оролцсон.<br>5. 2025 оны 05 дугаар сарын 09-15-ны өдрүүдэд APPU-аас зохион байгуулсан Дэлхийн шуудангийн 28-р их хуралтай холбогдуулан чадавхыг бэхжүүлэх цахим сургалтад хамрагдсан. | 01.02-06.10 | 100 |
| 2. | **Арга хэмжээ 2.** Төрийн албаны богино, дунд хугацааны мэргэшүүлэх сургалтад хамрагдана. | Сургалтад хамрагдсан эсэх | 0 | 1 | Төрийн албаны богино, дунд хугацааны мэргэшүүлэх сургалтад хамрагдах хүсэлтээ ТЗУГ-н хүний нөөцийн асуудал, дотоод сургалт хариуцсан ахлах шинжээчид өгсөн. | 01.02-06.10 | 100 |
| 3. | **Арга хэмжээ 3.** Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх А3 сургалтад хамрагдана. | Сургалтад хамрагдсан эсэх | 0 | 1 | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил,үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох (А3) сургалтад хамрагдсан. 2025 оны 06 сарын шалгалт өгөх хуваарьт бүргүүлсэн шалгалт өгөхөөр бэлтгэж байна. | 01.02-06.10 | 70 |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

Шуудан, өргөн нэвтрүүлэг, цахим худалдааны бодлого хариуцсан ахлах мэргэжилтэн ......Б. Тунгалаг...... / Б. Тунгалаг / 2025-06-10